



# ТЭСЭЛГЭЭНИЙ СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВИЙН ВЕБ ХУУДСАНД БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР


[www.tsst.mn](http://www.tsst.mn)

*Сануулга: Та бүхэн холбогдох мэдээллийг бөглөхдөө зөвхөн Кирилл үсэг болон цифр тоог (0,1-9) ашиглахыг анхаарна уу.*




# 1-Р АЛХАМ. ӨӨРИЙН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫГ ХЭРХЭН ЦАХИМ ХУУДСАНД БҮРТГҮҮЛЭХ ТАЛААР


1. Та өөрийн ашигладаг веб хөтөчөө ашиглан хайлтын цонх хэсэгт [www.tsst.mn](http://www.tsst.mn) хаягийг бичиж хайлт хийнэ.




2. Гарч ирсэн цонхонд байгууллагын регистрийн дугаар болон тэсэлгээний сургалт судалгааны төвөөс өгсөн нууц үгийг ашиглан нэвтэрч орно.



3. Нэвтрэн орсноор танд энэхүү цонх гарч ирэх бөгөөд **засах** хэсэгт дарж аж ахуй нэгжүүд мэдээллээ шинэчлэн оруулах шаардлагатай.



4. Засах хэсэгт нэвтрэн орсноор дараах цонх гарч ирнэ.



**Анхааруулга:** Энэ хэсэгт та бүхэн өөрийн аж ахуй нэгж байгууллагуудын холбогдох мэдээлэл (холбогдох утасны дугаарыг сургалт хариуцсан инженер ба хүний нөөцийн мэргэжилтэн гэх мэт Тэсэлгээний сургалт судалгааны төвтэй холбогддог хүний дугаар байна) болон улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл гэх мэт зүйлсийг үнэн зөвөөр ирүүлснээр бид бүхэн танай байгууллагын мэдээллийг нягтлан хүлээж авах болно.


**Тайлбар:** Тухайн бүртгүүлж байгаа байгууллага нь 3 төрлийн (1. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ хийх, 2. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, 3. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх) тусгай зөвшөөрөлтэй бол бүгдийн харин нэг тусгай зөвшөөрөлтэй бол байгаа тусгай зөвшөөрөл өө бүртгүүлэх юм.

Мэдээллээ шинэчилж оруулж дууссанаар тэсэлгээний сургалт судалгааны төвөөс таны оруулсан мэдээллийг шалган төлөвийг баталснаар танд бусад хэсэгт хандах эрх үүснэ. Файл оруулах хэсэгт дарж холбогдох бичиг баримтыг хавсаргах шаардлагатай. Файл дутуу илгээсэн тохиолдолд төлөв батлагдахгүй болохыг анхаарна уу. **Жич:** Инженер, техникийн ажилтан /ИТА/ шинээр бүртгүүлж буй тохиолдолд батлаагүй төлөвтэй байж болно.


## 2-Р АЛХАМ. ӨӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДЫГ ЦАХИМ СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ ТАЛААР

Байгууллага системд амжилттай бүртгүүлсний дараагаар өөрийн байгууллагад харьяалагдах тэсэлгээний ажлын удирдагч буюу “Мастер тэсэлгээчний үнэмлэх”, “Тэсэлгээчний нэгдсэн үнэмлэх” болон “Тэсэлгээний ажил тэсрэх материалтай харьцах” эрхийн үнэмлэхтэй инженер, техникийн ажилтнуудыг ангилан системд бүртгэнэ. **Тайлбар:** Үнэмлэхгүй шинээр үнэмлэх авах ажилчдаа системд бүртгүүлэх нь зүйтэй.

1. ИТА буюу (инженер, техникийн ажилтан) хэсэгт дарвал зурагт үзүүлсэн сонголтууд гарч ирнэ.





- Шинээр инженер техникийн ажилтан бүртгүүлэхдээ гарч ирсэн сонголтуудаас Шинээр ИТА бүртгүүлэх хэсгийг дарна. Холбогдох мэдээллүүдийг бөглөн үнэмлэхийн сканердаж оруулан (үнэмлэхийн эхний хуудас болон хамгийн сүүлд сунгалт хийсэн нүүртэй хамт) хадгалах хэсэгт дарна. Ингэснээр та өөрийн байгууллагын ажилчдаа цахим системд бүртгэлжүүлэн сургалтад хамруулах, цахим шалгалтад хамрагдах, хянах зэрэг олон давуу талтай болох юм.



**Анхааруулга:** Тухайн бүртгүүлж буй инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг үнэн зөв бөглөх ба үнэмлэхийн дугаарт (000/0000) гэх байдлаар оруулах юм. **Жишээ нь:** 021/2020, 001/2020 гэх мэт.

- Холбогдох мэдээллүүдийг бөглөн хадгалснаар танай байгууллагын инженер, техникийн ажилтнуудын бүртгэл ангилагдан орох болно. **Тайлбар:** Та бүртгүүлсэн ажилтныхаа мэдээллийг засах хэсэгт даран дахин шинэчлэх боломжтой.



Овог	Нэр	Тэслэгээчийн үнэмлэхний зураг /jpg, png, pdf өргөтгөлтэй файл хүлээн авна/	Үнэмлэхний дугаар	Үнэмлэхний хүчинтэй хугацаа	Төлөв	Үйлдлүүд
Шутис	Гуус		020/2020	2021-01-27	Батлаагүй	Харах, Засах, Устгах